БАТЛАВ.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.............................. Б.ДАШПҮРЭВ

**“ПАЛЕОНТОЛОГИЙН НӨӨЦӨД ТУЛГУУРЛАН АЯЛАЛ-СУДАЛГАА-АМРАЛТЫН ЦОГЦОЛБОР” БАЙГУУЛАХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕНДЕРИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 05 дугаар сарын 31-нд Улаанбаатар 2023

| Д/д | Ажлын нэр, төрөл | Тайлбар |
|---|---|---|
| **1.** | **Ажил гүйцэтгэх үндэслэл** | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050"-д тусгагдсан дараах зорилгууд урт хугацааны бодлогын үндэслэл болж байна:<br>• Байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, түүх, соёл, рекреацийн нөөц, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлнэ.<br>• Говийн аймгуудад палеонтологи болон нэн ховор амьтдын парк, түүх, шашин, соёлын өв уламжлал, байгалийн ландшафт, рашаан сувилалд түшиглэсэн амралт, нөхөн сэргээх аялал жуулчлалын цогцолбор байгуулна.<br>• Археологи, палеонтологийн судалгааг үнэт зүйлийн судалгааны тэргүүлэх чиглэл болгож, үндэсний хэмжээний судалгааны төслийг хэрэгжүүлэх.<br>• Монгол Улсын соёл, аялал жуулчлалын төвүүдийг зорилтот зах зээлийн орнуудад байгуулж, гадаад сурталчилгааг сайжруулан, аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлэх,<br>• Хөвсгөл нуур, Хангайн нурууны экосистем, томоохон голуудын сав дагуух адал явдалт болон Говийн бүсэд нутгийн онцлогт тохируулан палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын цогцолбор байгуулах.<br>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэж заасан нь дунд хугацааны бодлогын үндэслэл болж байна.<br><br>Монголын үлэг гүрвэлийн үзэсгэлэнг 1985 оноос хойш таван тивийн 20 гаруй орны 80 хотод үзүүлсэн бөгөөд жилд дунджаар 100,000 орчим хүнд хүрдэг байна. Хамгийн сүүлийн үеийн жишээг дурдвал Япон улсын Байгалийн түүхийн музейд “Динозавр экспо-2019” дэлхийн үзэсгэлэн зохион байгуулагдаж Монголоос олдсон Дейнохер үзвэр гол үзэсгэлэн болж 3 сарын хугацаанд 700,000 гаруй үзэгч үзэн сонирхсон байна. (ШУА, 2020) Монголын үлэг гүрвэлийн олдвор хэдийнээ дэлхийд танигдсан бөгөөд тус олдворуудыг зорьж ирэх жуулчдын томоохон таталцал говийн бүсэд байгаа нь “Палеонтологийн нөөцөд тулгуурлан Аялал-судалгаа-амралтын цогцолбор” |

| | | |
|---|---|---|
| | | байгуулах төслийн практик хэрэгцээ шаардлага болоод байна. Монгол Улсад аяллын нийтлэг загвар нь шугаман байдаг нь аяллын маршрутыг дагасан бүтээн байгуулалт, орлогыг нэмэгдүүлэхэд улирлын шинж чанартай болгож байна. Иймээс олон улсын туршлагад үндэслэн цогцолбор байдлаар аялал-судалгаа-амралт маягаар төр-хувийн хэвшил-нутгийн иргэдийн хамтын ажиллагаагаар аялал жуулчлалын жишиг бүтээн байгуулалтыг хийх зайлшгүй шаардлага үүсээд байна. |
| **2.** | **Ажлын зорилго** | Ажлын зорилго нь Монголын үлэг гүрвэл, палеонтологийн нөөцөд тулгуурлан олон улсын жишигт нийцсэн нутгийн иргэдийн орлогыг дэмжсэн аялал-судалгаа-амралтын цогцолборын бүтээн байгуулалтыг эхлүүлж шинжлэх ухаан, адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэх юм. |
| **3.** | **Шийдвэрлэх үндсэн асуудал** | "Палеонтологийн нөөцөд тулгуурлан Дундговь аймагт байгуулах аялал-судалгаа-амралтын цогцолборын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах" ба дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:<br>1. Тухайн бүс нутагт эртний нүүдэлчдийн түүх, өв соёл, ёс заншил бүхий түүхэн газар, унаган байгаль, тэдгээрийн цогцолборт газрууд, түүхэн дурсгалт газар, булш, бунхан, хиргисүүр, хадны сүг зураг, археологи, палеонтологийн олдвор газруудыг судлах, хамгаалах, олон нийтэд таниулан сурталчлах, тухайн газар нутаг дахь амралт, судалгаа шинжилгээний газрууд, бусад аялал жуулчлалын чиглэлүүдтэй нягт уялдуулсан аялал жуулчлалын бүсийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлж, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын өнөөгийн байдал, аялал жуулчлалын зориулалтаар ашиглах боломжийн талаар үнэлгээ хийж цогц хэлбэрээр хэрхэн хөгжүүлэх талаарх төлөвлөлтийн, менежментийн болон эдийн засгийн судалгаа тооцоолол, ТЭЗҮ болон тухайн аялал жуулчлалын бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хувилбарыг боловсруулах;<br>2. Дундговь аймгийн аялал жуулчлалын бүс орчмын болон Говийн аймгуудын зарим сумдын түүхэн эх сурвалжийн хувьд ач холбогдолтой, байгалийн онцгой цогцолбор бүхий тодорхой нутаг дэвсгэрийг холбосон аяллын үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, тухайн бүсийн тусгайлан хөгжүүлэх цэгүүдэд аялал-судалгаа-амралтын цогцолбор /логистик/ төв болон мэдээллийн төв бүхий логистикийн төвүүдийг байгуулах хамгийн оновчтой байршил, газрыг холбогдох эрх бүхий байгууллагуудын хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо болон Засгийн газраас баримталж буй чиглэлтэй уялдуулан тодорхойлох. Ингэхдээ Аялал-судалгаа-амралтын цогцолбор төв болон мэдээллийн төвийн хэмжээ, хүчин чадал, тэдгээрт үзүүлэх үйлчилгээний хэлбэр зэргийг дээр дурдсан чиглэлийн хүрээн дэх тодорхой сэдвүүдтэй нийцүүлэн тодорхойлж, тухайн газар нутгийн түүхийн болон байгалийн онцлогийг үндэсний хэв маягийг орчин үеийн төлөвлөлтийн шийдлүүдтэй уялдуулах, шаардагдах санхүү хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцооны хамт боловсруулах.<br>3. "Палеонтологийн нөөцөд тулгуурлан Дундговь аймагт "Аялал жуулчлал-судалгаа-амралтын цогцолбор төв" байгуулах, мэдээллийн төв байгуулах газрын оновчтой байршлыг тогтоож, "Аялал жуулчлал-судалгаа-амралтын цогцолбор төв"-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хувилбарыг гаргах;<br>Аялал жуулчлал-судалгаа-амралтын цогцолбор төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:<br>**А: Түүх соёл, аялал жуулчлалын хэсэг:** |

| | | |
|---|---|---|
| | | - Музейн хэсэг /үндсэн үзвэр-дотор-гадаа/<br>- Залуу судлаачдын хэсэг<br>- Хадны сүг зургийн үзэсгэлэнгийн танилцуулгууд<br>- Палеонтологийн олдвор үзвэрийн хэсэг<br>**Б. Судалгаа, эрдэм шинжилгээний хэсэг:**<br>- Судалгааны музей<br>- Номын сан /уламжлалт болон цахим/<br>- Хурлын танхимууд<br>- Судалгаа, эрдэм шинжилгээний өрөөнүүд<br>- Лабораториуд<br>- Инновац хөгжүүлэлтийн хэсэг<br>**В. Амралтын хэсэг:**<br>- Зочид буудал<br>- Худалдаа үйлчилгээ<br>- Ресторан<br>- Алжаал тайлах төв<br>**Г. Энтертайнмент хэсэг:**<br>- Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ<br>- Кино театр /Задгай, дотор асар/<br>- Чөлөөт цаг өнгөрөөх хэсэг /фестивал, үйлчилгээ/<br>- Эвент арга хэмжээ / Jurassic Park /<br>- Задгай цирк /Тэмээтэй үзүүлбэр/<br>- Тоглоомын талбай |
| 4. | **Ажлын иж бүрдэл** | Ажил дараах үндсэн 2 иж бүрдэлтэй байна. Үүнд:<br>**1. ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ**<br>1.1. ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА,<br>• Хууль, эрх зүйн судалгаа<br>• Нийгмийн судалгаа<br>• Эдийн засгийн судалгаа<br>• Олон улсын нөхцөл байдал<br>1.2. ӨГӨГДӨЛ МЭДЭЭ БОЛОВСРУУЛАЛТ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ;<br>• Ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, түүний туршлага судлах<br>• Өнөөгийн байдлыг тодорхойлох<br>• Аялал жуулчлал-судалгаа-амралтын цогцолбор байгуулах тооцоо судалгаа хийх, хүний нөөц, ажиллах орчны тооцоо боловсруулах<br>• Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг судлах,<br>• Аялал жуулчлал-судалгаа-амралтын цогцолбор байгуулах эрх зүйн орчны судалгаа хийх<br>1.3. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ<br>• Макро орчны шинжилгээ<br>• Микро орчны шинжилгээ<br>• Нийгэм, эдийн засгийн шинжилгээ<br>• Хууль, эрх зүйн шинжилгээ<br>• Эрсдэлийн шинжилгээ<br>• Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын шинжилгээ<br>1.4. ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШИНЖИЛГЭЭ:<br>• "Эрэлтийн шинжилгээ<br>• Нийлүүлэлтийн шинжилгээ<br>• Зөрүүгийн шинжилгээ |

1.5. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ БОЛОН ЦАР ХҮРЭЭ ТОДОРХОЙЛОХ;

- Үндэслэл тодорхойлох
- Зорилго, зорилт, хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
- Ажлын тоо, хэмжээг тодорхойлох
- Ажлын хамрах хүрээг тодорхойлох
- Төслийн амжилтын хүчин зүйлс, нийгэм эдийн засгийн үр нөлөөг тодорхойлох

1.6. ТӨСЛИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ;

- Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн сонголт, бүтээлийн тооцоо
- Төслийн онцлогоос хамаарах бусад шийдлүүдийг тодорхойлох

1.7. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ;

- Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн төлөвлөлт
- Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт

1.8. ТӨСЛИЙН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО:

- Төслийн санхүүгийн тооцоолол
- Хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний зарцуулалт
- "Санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь

1.9. ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОХ

**2. "АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ-СУДАЛГАА-АМРАЛТЫН ЦОГЦОЛБОР ТӨВ"-ИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:**

2.1. АРХИТЕКТУР ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГЛАЛ:

- Байршлын схем М1:50000;
- Орчны тойм М1:25000;
- Бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд холбогдсон байдал, байршлын тойм зураг М1 :5000;
- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг М1 :2000;
- Нутаг дэвсгэрийн чиг үүргийн бүсчлэлийн зураг М1 :2000;

2.2. ЦЭЦЭРЛЭГЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ:/М1 :2000/

- Ногоон байгууламж/нийтийн, хязгаарлагдмал, тусгай зориулалтын/;

2.3. ЗАМ, ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ: /М1 :2000/

- Гудамж, замын сүлжээ;

2.4. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ: /М1 :2000/

- Инженерийн хангамжийн эх үүсвэрүүд, шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт
- Инженерийн бэлтгэл арга хэмжээ;
- Дулаан хангамж;
- Цахилгаан хангамж:

| | | |
|---|---|---|
| | | – Усан хангамж;<br>– Ариутгах татуурга;<br>– Холбоо мэдээлэл;<br>2.5. ТАЙЛБАР БИЧИГ:<br>- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан үндэслэл, зорилго, хамрах хүрээ, бүрэлдэхүүн, аргачлал, арга зүй;<br>- Судалгаа, шинжилгээ, тооцооллын дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо;<br>- Орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл;<br>- Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө<br>- Хөрөнгө оруулалтын томсгосон тооцоо |
| 5. | **Ашиглах материал** | **Хууль, дүрэм, журам:**<br>- Үндсэн хууль;<br>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;<br>- Хот байгуулалтын тухай хууль;<br>- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль;<br>- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;<br>- Газрын тухай хууль;<br>- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;<br>- Барилгын тухай хууль;<br>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;<br>- Усны тухай хууль;<br>- Ойн тухай хууль;<br>- Соёлын өвийг хамгаалах тухай хууль;<br>- Монгол Улсын Инновацийн тухай хууль;<br>- Ойн тухай хууль;<br>- Эрчим хүчний тухай хууль;<br>- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль;<br>- Хөрс хамгаалах тухай хууль,<br>- Газрын хэвлийн тухай хууль,<br>- "Харилцаа холбооны тухай хууль", Хот байгуулалтын баримт бичиг: Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"<br>- Бусад хуулиуд;<br>**Норм, нормативууд:**<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04);<br>- Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09);<br>- Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УБ11-202-00);<br>- Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах аргачилсан заавар (УБ 30-202-11);<br>- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа 1:500, 1000, 2000, 5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил (БД 11-106-08);<br>- Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил (БД 11-105-06)-ыг үндэслэн байр зүйн зургийн тодруулалт хийсэн дэвсгэр зураг ашиглах;<br>- Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07); |

| | | |
|---|---|---|
| | | - Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм (ЗТБХБ-ын сайдын 2011 оны 226 дугаар тушаал);<br>- Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ (БД 81-106-16);<br>- Барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн индекс;<br>- Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БНбД 32-01-04);<br>- Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт (БНбД 23-01-09);<br>- Гадна дулаан хангамж (БНбД 41-02-13);<br>- Ариутгах татуурга, Гадна сүлжээ ба байгууламж (БНбД 40-01-14);<br>- Усан хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам (БД 40-102-06);<br>- Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм (БД 43-101-03);<br>- Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал (БНбД 21-01-02);<br>- Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл (БНбД 21-04-05);<br>- Авто зам төсөллөх (БНбД 32-01-07);<br>- Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж (БНбД3.05.04-90);<br>- Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж (БНбД 40-02-06);<br>- Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам /БНбД 33-01-03/<br>- Дулааны сүлжээ (БНбд 41-02-13);<br>- Дулааны шугам сүлжээ (БНбд 3-05-03-95);<br>- Дулааны хуваарилах төв (БНбд 41-103-11);<br>- Дулааны бие даасан эх үүсвэрийн төлөвлөлт (БНбд 41-102-11);<br>- Цэвэрлэгээний технологи сонголт, бохир усны БНбД40-01-14;<br>- Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ түүний барилга байгууламж /БНбД3.05.04.90/;<br>- Усан хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам БД40-102-06;<br>- Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам; (ЗТБХБ-ын сайдын 183 дугаар тушаал);<br>- MNS 3237:1989 Ерөнхий төлөвлөгөө. Зам тээврийн таних тэмдэг, дүрслэл;<br>- MNS 5873:2008 Барилгын зураг. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ;<br>- MNS 6055:2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар;<br>- Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм /БД 43-101-03/;<br>- Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм;<br>- Холбооны кабель шугамын ажлын зураг төсөв хийх стандарт MNS 6305:2012;<br>- Шилэн кабелийн угсралт суурилуулалтын стандарт MNS 5278:2012;<br>- Холбооны кабелийн суурилуулалт, ерөнхий шаардлага MNS 5276:2003; |

| | | |
|---|---|---|
| | | - Техникийн зурагт телефон сүлжээний тэмдэглэгээ, тэмдэглэгээний хэмжээ MNS-4908;<br>Бусад хот байгуулалт, барилга байгууламжийн норматив баримт бичиг, норм, дүрэм, заавар. |
| 6. | **Зураг төсөл боловсруулах ажлын үе шат** | ***Эхлэлийн тайлан боловсруулах ажлын үе шат:***<br>- Арга зүй, аргачлалыг тодорхойлох, хот байгуулалтын болон даалгаварт тусгагдсан бусад шаардлагатай суурь судалгаа хийх;<br>***Дундын тайлан боловсруулах ажлын үе шат:***<br>- Техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардлагатай үнэлэлт, дүгнэлт, тооцоо, ОУ-ын туршлагын судалгаа<br>- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэл<br>- Санал авах, хэлэлцүүлэх;<br>***Эцсийн тайлан боловсруулах ажлын үе шат:***<br>- Холбогдох байгууллагуудаас санал авах;<br>- ТЭЗҮ-н тайлан<br>- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийн бүрдэл, тайлбар бичиг<br>- Зөвшөөрөлцөх, батлуулах; |
| 7. | **Захиалагч байгууллага** | Эдийн засаг, хөгжлийн яам |
| 8. | **Тендерт оролцогчийн багийн гишүүдэд тавигдах шаардлага** | Заавал шаардагдах багт дараах мэргэжилтнүүд:<br>1. Сээр нуруутны палеонтологич/Геопаркын эксперт/<br>2. Палеонтологийн сан хөмрөг, бүртгэл мэдээллийн ажилтан<br>3. Палеонтологийн чиглэлээр музей судлаач, дэглэгч /mold-cast making experience/<br>4. Давхарга зүй, хурдас хуримтлалын судлаач<br>Мэргэжлээрээ 10 ба түүнээс жил ажилласан, эрдмийн зэрэг цолтой, олон улсын түвшинд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх.<br>1. Газарзүй, геоморфологич<br>2. Аялал жуулчлалын мэргэжилтэн<br>3. Хот төлөвлөлтийн зөвлөх эдийн засагч<br>4. Хот төлөвлөлтийн мэргэшсэн эдийн засагч<br>5. Хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор<br>6. Газар зохион байгуулалтын зөвлөх инженер<br>7. Геодезийн инженер |
| 9. | **Зураг төсөл боловсруулах хугацаа** | Гэрээ байгуулснаас хойш 12 сар |
| 10. | **Гүйцэтгэгч байгууллага** | - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу сонгон шалгаруулсан хуулийн этгээд. |
| 11. | **Санхүүжилт, эх үүсвэр** | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар |
| 12. | **Санхүүжилт** | 700,000,000 төгрөг |
| 13. | **Хүлээн авах материал** | - Ажлын иж бүрдэл хэсэгт туссан судалгаа шинжилгээ, зураглал, тайлан, тооцоо, видео зэргийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн программ хангамжийн эх хувилбараар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүлээлгэж өгөх /4 хувь/ |

---oOo---